

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 26 ДУГААР ХУРАЛДААН

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 26 дугаар хуралдааныг 09 цаг 20 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 69.2 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Хог хаягдлын менежментийг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хог хаягдлын менежментийг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Л.Батбаярт үүрэг болгов.
2	“Залуу малчин, тариаланч” аймгийн дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Залуу малчин, тариаланч” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, мэргэжилтэн Ц.Пүрэвсүрэн нарт үүрэг болгов.
3	“Шинэ Ховд бизнес хөгжлийн төв” сан байгуулах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Шинэ Ховд-бизнес хөгжлийн төв” нэртэй сан байгуулах асуудлыг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг “Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨААТҮГ-ын дарга Ш.Батжаргалд үүрэг болгов.
4	“Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн парк”, “Ховд Агро парк” ХХК-уудыг өөрчлөн байгуулах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн парк”, “Ховд Агро парк” ХХК-уудыг өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэх явцад аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг “Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨААТҮГ-ын дарга Ш.Батжаргалд үүрэг болгов.
5	Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн парк” болон “Ховд Агро парк” төслийн хүрээнд хэрэгжих төслүүдийг иргэд олон нийтэд нээлттэй байдлаар зарлаж, сонгон шалгаруулалт явуулах ажлын талаар хэлэлцэх явцад аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг “Шинэ Ховд” ББХК-ийн захирал Ш.Батжаргалд үүрэг болгов.
6	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас ирүүлсэн 2021 оны 10 дугаар сарын 22-

	мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	ны өдрийн 4/520 дугаар чиглэлийн дагуу “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзоригт үүрэг болгов.
--	---	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР